



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 09 сарын 22 өдөр

Дугаар А/325

Улаанбаатар хот

Комиссын бүрэлдэхүүнийг батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйл, 78 дугаар зүйлийн 78.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн “Хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтыг дэмжих төв” ОНӨААТҮГ-аас дүүргийн төсвийн хөрөнгө оруулалт, урсгал зардлаар хийгдсэн зам талбайн тохижилт болон бүтээн байгуулалтын ажлыг хүлээн авч байнгын ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын ахлагч

Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга

Гишүүд

Засаг даргын Тамгын газрын Хотын стандарт, тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн дарга

Засаг даргын Тамгын газрын Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтсийн дарга

Засаг даргын Тамгын газрын Архивын хэлтсийн дарга

Чингэлтэй дүүргийн Газар зохион байгуулалтын алба

Чингэлтэй дүүргийн Нийтлэг үйлчилгээний газар ОНӨТҮГ

1-24 дүгээр хорооны Засаг дарга

Зураг төслийн компани (зөвшилцсөнөөр)

Нарийн бичгийн дарга

Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн Орон нутгийн өмч хариуцсан мэргэжилтэн

2. Энэхүү захирамжийг үндэслэн зам талбайн тохижилт, бүтээн байгуулалтын

1525010979

ажлыг хүлээн авах комиссын бүрэлдэхүүн, ажиллах хуваарь батлахыг Засаг даргын Тамгын газар (Ж.Тамир)-т зөвшөөрсүгэй

3.Комиссын үйл ажиллагааны явц, үр дүнг дүүргийн Засаг даргад тухай бүр танилцуулахыг ажлын хэсэг (М.Навчаа)-т үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан дүүргийн Засаг даргын 2025 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/242 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (З.Бямбажав)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.МАНДУУЛ